

2026 оны хичээлийн жилийн 2-р улирлын дотуур байрны нэмэлт элсэлтийн байрлах тухай мэдээлэл

2026 оны хичээлийн жилийн 2-р улирлын дотуур байрны нэмэлт элсэлттэй холбоотой мэдээллийг дараах байдлаар хүргэж байна. Та бүхнийг энэхүү мэдээлэлтэй сайтар танилцаж, заасан хугацаанд хүсэлтээ гарган, төлбөрөө төлөхийг хүсье.

1. Хүсэлт гаргах эрхтэй хүмүүс: 2026 оны хичээлийн жилийн 2-р улирлын суралцаж буй оюутан, эргэн суралцах оюутан зэрэг (төгсөгч, чөлөө авсан оюутан, сургуулиас хасагдсан оюутан хамрагдахгүй).

2. Хүлээн авах хүний тоо: 2-р улиралд дотуур байранд орохоос татгалзсан болон 1-р улирлын дундуур байрнаас гарсан оюутнуудын улмаас гарсан сул өрөөнүүдийн тоогоор

3. Хүсэлт гаргах, бүртгүүлэх хугацаа: 2026.07.27 (Даваа) - 2026.08.06 (Пүрэв) 16:00 цаг хүртэл.

4. Хүсэлт хийх арга: Портал систем → 생활관 → 입사신청(өөрийн орох дотуур байрыг сонгох, давхцан бүртгүүлэх боломжгүй)

5. Төлбөр төлөх арга(зөвхөн тэнцэгчид)

가. Тэнцэгчийг зарлах: 2026. 8. 7.(Ба) 11:00

나. Төлбөрийн нэхэмжлэл: [확인하기](#) шалгах

다. Төлбөр төлөх хугацаа: 2026. 8. 7.(Ба) 11:00~2026. 8. 12.(Лхаг) 16:00 хүртэл

라. Төлбөр төлөх арга: [포털시스템](#) Портал систем → 생활관 дотуур байр → 고지서 가상계좌 확인 [төлбөр төлөх нэхэмжлэл](#) ,данс шалгах → 신한은행(가상 계좌 납부) шинхан банк

6. Байрлах хугацаа ба төлбөр

Байранд орох хугацаа	Ашиглах хугацаа	Дотуур байр		
		Дотуур байр	1хүний өрөө	2хүний өрөө
2026. 8. 31.(Да)~ 9. 4.(Ба)	2026. 8. 31.(Дав)~ 12.22.(Мя) 16:00хүртэл	Бэкхагса, Green village	1,218,000вон	812,000вон
		Global house	1,431,000вон	954,000вон

※ Төлбөрөө хугацаанд нь төлөөгүй тохиолдолд дотуур байранд орох эрх хүчингүй болно.

※ Байрнаас татгалзах эцсийн хугацаа: 2026. 8. 30.(Ням) 16:00хүртэл

7. Дотуур байрны хоол

Дотуур байр	Сонголт	
	1өдөрт 1хоол (75удаа/4,200вон)	1өдөрт 2хоол (150удаа /3,900вон)
Бэкхагса, Global house	315,000вон	585,000вон

가. Нэхэмжлэл анх өдөрт 1 хоолтой гарна.

나. Өдөрт 2 хоол хүсвэл хичээл эхэлсний дараа хоолны газарт тусад нь хүсэлт гаргана.

Ц.Буцаан олголт зөвхөн элсэлт, дадлага, цэргийн сургалт зэрэг нотлох баримттай тохиолдолд боломжтой.

Хоолны цаг :Өдрийн хоол: 11:30-13:30 ,Оройн хоол: 17:30-19:00

Өглөөний цай байхгүй.

Амралтын өдөр болон бҮх нийтийн баяраар ажиллахгүй.

8. 2026оны 2р улирлын дотуур байрны эрт нэвтрэх хугацаа ба төлбөр

Урьдчилж орох хугацаа	ХҮсэлт гаргах арга	1өдрийн төлбөр			
		Байр	1хҮний өрөө	2хҮний өрөө	
2026. 8. 22.(Бям)~ 2026. 8. 30.(Ням)	Системээр хҮсэлт гаргасны дөрөө төлбөр төлнө. Дэлгэрэнгүй мэдээллийг дараа нь зарлана	Бэкхагса, Green village	15,000 вон	10,000 вон	Зөвхөн өрөө урьдчилсан сул өрөөтэй тохиолдолд эрт байрлах боломжтой. ХҮсэлт гаргаж, эрт байрлах төлбөрөө төлсөний дараа ашиглах боломжтой
		Global house	18,000 вон	12,000 вон	

9. БҮрдҮүлэх материал: СҮрьеэгийн шинжилгээний хариу

᠑. 2026 оны 8-р сараас хойш хийлгэсэн шинжилгээ хҮчинтэй. 1-р улиралд өгсөн байсан ч 2-р улиралд дахин өгөх шаардлагатай

→ Хугацаанд нь өгөөгүй бол торгуулийн оноо авч, хуримтлагдвал албадан гаргана.

᠒. Ойролцоох эмнэлэг эсвэл эрҮүл мэндийн төвд шинжилгээ өгөөд хариугаа өгнө.

᠓. Их сургуулийн эрҮүл мэндийн төвөөр шинжилгээ өгөх боломжтой бөгөөд дараа нь сургуулиас тусгайлан зарлана.

᠔. Халдварт сҮрьеэтэй бол дотуур байранд оруулахгүй байж болно.

10. Байранд орох дараалал

᠑. Дотуур байрны 1 давхрын оффист очно. Өрөөний тҮлхҮүр, матрасны бҮрээсээ авна.
→ Өрөөндөө орно.

᠒. Матрасны хэмжээ: Дотуур байрнаас өгөх бҮрээс болон өөрийн матрасны бҮрээс авч ашиглаж болно

1) Глобал Бэкхаг: 200 × 100 × 25 см

2) Global House: 198 × 98 × 21 см

11. Бэлтгэх зҮйлс ба хориглосон зҮйлс

᠑. Бэлтгэх зҮйлс: Оюутны Үнэмлэх, Матрасны дэвсгэр (зузаан хөвөн матрас хэрэглэхгүй) Хөнжил, Дэр, Ариун цэврийн хэрэглэл, Хувийн хэрэглээний зҮйлс

᠒. Оруулж болохгүй зҮйлс: Цахилгаан халаагуур, Цахилгаан хөнжил, Цахилгаан тогоо, Хийн плитк, Индукц, Богино долгионы зуух, Кофе чанагч, Талх шарагч зэрэг галын аюултай цахилгаан хэрэгсэл

※ Хориглосон эд зҮйлээс Үүдэлтэй бҮх хохирлыг тухайн оюутан өөрөө хариуцна

᠓. Оруулж болох цахилгаан хэрэгсэл: Компьютер, Дагалдах төхөөрөмжүүд, Ширээний гэрэл, 50 литрээс бага хөргөгч, Сэнс, Цэнэглэгч, Үс хатаагч, Аудио төхөөрөмж

᠔. Илгээмж: Байранд орохоос өмнө хҮрсэн илгээмж алдагдах эрсдэлтэй тул орох өдөр эсвэл тҮүнээс хойш хҮрэхээр илгээнэ Үү.

12. Өрөө сонгох

᠑. Портал → 생활관 → 호실신청 → хҮссэн өрөөг сонгох

᠒. Хугацаа 2026.08.20 13:00 - 2026.08.23 17:00 өөрөө хҮсэлтээ хийх

1) Өрөө сонгох хуваарь өөрчлөгдөж болно.

2) 1 хҮний өрөөний хҮсэлт гаргасан оюутнуудын дунд сугалаагаар хуваарилна.

13. AI өрөөний хамтрагч (AI Roommate Matching)

᠑. ХҮсэлт гаргах оюутад: 2026 оны 2 улиралын Дотуур байранд орох оюутнуудаас зөвхөн хҮсэлт гаргасан хҮмҮүс хамрагдана.

᠒. ХҮсэлт гаргах хугацаа 2026.08.14 - 2026.08.17

1) Зөвхөн хҮсэлт гаргасан оюутнуудад зориулсан, AI хамтрагч хҮссэн бол өрөө өөрөө сонгох боломжгүй.

2) Давхрыг санамсаргүй байдлаар хуваарилна, Дэлгэрэнгүй мэдээллийг 8-р сард зарлана.

14. Холбоо барих

Бэххагса	Global house	Green village
Эрэгтэй байр 062-608-5961 Эмэгтэй байр 062-608-5952	062-608-5155~6	062-608-5000

2026. 7.



취업학생처장